



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 3/20


Ховд

Б.Энхбадрахыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.4, 67.4, 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бадамрайн Энхбадрах нь аймгийн Засаг даргын жолоочоор ажилд орох хүсэлт гаргасан тул 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 3 сарын туршилтын хугацаагаар аймгийн Засаг даргын жолоочоор томилсугай.
2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.
3. Б.Энхбадрахыг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга (Б.Нямдэлгэр)-д үүрэг болгосугай.
4. Б.Энхбадрахыг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ"-ний ТҮ-3 дахь зэрэглэл буюу 569585 (таван зуун жаран есөн мянга таван зуун наян тав) төгрөгөөр цалинг тооцож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ДАРГ



Д.ЭНХБОЛД

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2022 оны 10 дугаар сарын 28-ны
өдрийн В/90 дүгээр тушаалын хавсралт

АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн
ахлагч:

Б.Энхмандал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
нягтлан бодогч)

Гишүүд:

М.Лхагвасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү, аж ахуйн тасгийн жолооч)

Нарийн бичгийн
дарга:

Х.Болормаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү, аж ахуйн тасгийн нярав)

-оОо-